

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2009 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2009 онд аймгийн ЗДТГ, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын ирэх дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрийг бүхэлд нь хэрэгжүүлэх үндэс суурийг тавихад гол анхаарлаа төвлөрүүлэн ажиллаа. Ийм боломж бүрдүүлэхийн тулд юуны өмнө гарааны нөхцөл буюу аймаг, орон нутгийнхаа өнөөгийн бодит байдал, давуу болон сул талаа зөв үнэлж дүгнэн өөрийн нөөц боломжийг оновчтой ашиглах, хөрөнгө хүчээ хамгийн үр ашигтай хуваарилан дайчилж ажилласан болно.

Тус аймаг нь ажиллах хүч, мэргэжилтэй боловсон хүчний хангалттай нөөцтэй, олон үндэстэн ястны өвөрмөц соёл, зан заншил, хөдөлмөрч уламжлалтай, өрхийн аж ахуй эрхлэх ардын уламжлалт технологитой, мөнгө, вольфром, полиметалл төмөр, алтны ирээдүй бүхий орд илэрцтэй, байршлын хувьд ОХУ, БНХАУ-тай хил залгаа оршдог, шууд харилцах хилийн боомттой, Казахстан, Турк улстай байнгын шууд харилцаатай, эдгээр орнуудтай худалдаа эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах, эдийн засгийн интеграцид идэвхтэй оролцох өргөн боломжтой зэрэг өвөрмөц давуу талтай юм. Гэвч манай аймаг төвийн бүс төвлөрсөн зах зээлээс хэт алслагдсан, өндөр уулын эрс тэс уур амьсгалтайн улмаас газар тариалан эрхлэх, хадлан, малын тэжээл бэлтгэх боломж тун хомс, МАА нь эрчимжээгүй, нэгжээс ашиглах ашиг шим бага, ажилгүй хүн их боловч мэргэжилгүй, мэргэжлийн чадавхи багатай, үйлдвэрлэл, түүний дэд бүтэц, сул хөгжсөн, ажилгүйдэл, ядуурлын түвшин харьцангуй өндөр зэрэг сул тал, хүндрэл бэрхшээлтэй болохыг тогтоож тавьсан зорилгоо ханган биелүүлэх ажилдаа байнга харгалзан тооцож байлаа.

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар аймгийнхаа эдийн засаг, нийгмийн давуу талдаа түшиглэн сул тал, бэрхшээлийг даван туулах, улмаар тэдгээрийн хөгжилд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгийн гол нь эхний ээлжинд хүмүүсээ ажилтай, орлоготой болгох замаар иргэдийнхээ эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн бусад асуудлыг үе шаттай шийдвэрлэх бодлого, чиглэл гарган ажиллаж ирлээ.

Нэг. Үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх талаар тавьсан зорилтын биелэлтийн явц байдал

Мөрийн хөтөлбөрт үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх талаар дэвшүүлсэн зорилтуудаас 2009 онд 136 ажил хийхээр төлөвлөж, үндсэнд нь ханган биелүүлсэн гэсэн дүн мэдээ гарч байна. Эдгээрээс томоохныг нь дурьдахад Улаанхус сум Согогийн баг, Цагааннуур-Улаанбайшинтын чиглэлийн 10кВт-ын болон Өлгий-Цагааннуур-Ногооннуур сумыг холбосон 35 кВт-ын ЦДАШ-ыг дэд станцын хамт барьж ашиглалтанд оруулсны дээр Ховдын Дуутаас Өлгийн Булган сум хүртэлх 15 кВт-ын 109 км ЦДАШ-ын

барилгын үндсэн ажлыг хийж, ирэх оны эхний хагаст багтаан ашиглалтанд авахад бэлэн болгосноор аймгийн нийт сумдыг баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн системд бүрэн холбох томоохон зорилтыг шийдвэрлэх боломж бүрдэж байна.

2009 онд аймгийн хэмжээний дэд бүтэц, зам, гүүр барилгын салбарт 2,15 тэрбум төгрөгийн ажил хийгдсэний дотор Сагсай сумын Турганы гол дахь бетон гүүрний барилгын ажлыг дуусгаж, Улаанхус сумын 181,8 ийн урттай томоохон бетон гүүрийг 2010 онд ашиглалтанд оруулах боломж бүрдлээ. Өнгөрсөн онд Булган сумын Булган гол, Дэлүүн сумын Ганц модны гол, Алтай сумын Сагсайн голуудад нийт 83 урт метр модон гүүрийг орон нутгийн замын сангийн хөрөнгөөр шинээр барилаа. Түүнчлэн 2009 онд Өлгий Цагааннуурын хатуу хучилттай 30 км замыг үргэлжлүүлэн барих 13 тэрбум төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлж, гүйцэтгэгчийг нь тодруулан газар шорооны ажлыг эхлүүлснээр энэ замыг 2011 онд багтаан дуусгах боломжтой боллоо. Баруун бүсийн автозамыг хөгжүүлэх төслийн хүрээнд Өлгий-Хашаатын чиглэлийн хатуу хучилттай автозамыг БНХАУ-ын 50,0 сая ам долларын хөнгөлөлттэй зээлээр 2010 оны эхний улирлаас эхлэн барихаар эцэслэн шийдвэрлэсэн болно.

Энэ салбарт хийгдэж байгаа бас нэг томоохон ажил бол Өлгий хотын Нисэх буудлын 11,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй хатуу хучилттай зурвас, 1,7 тэрбум төгрөгийн өртөгтэй спорт цогцолборын барилгын ажил идэвхтэй явагдаж, баруун бүс нутагт томоохонд тооцогдох энэ хоёр объектыг ирэх онд аймаг байгуулагдсаны 70 жилийн ойн өмнө ашиглалтанд оруулахаар шамдан ажиллаж байгаа явдал юм.

2009 онд үйлдвэрлэлийг дэмжих жилийн ажлын хүрээнд улсын төсвөөс олгосон 763,0 сая төгрөгийг хүнс, ХАА-н үйлдвэрлэл, хөнгөн болон барилгын материалын үйлдвэр, эм бэлдмэл, ахуйн болон худалдаа үйлчилгээ гэсэн 8 үндсэн чиглэлээр төсөл шалгаруулан 83 аж ахуйн нэгжийг хамгийн хөнгөлөлтэй нөхцлөөр зээлжүүлснээр 361 иргэн ажилтай, орлоготой болох нөхцөл бүрдсэн байна. Энэ нь орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн томоохон алхам бөгөөд үүний үр дүнд ажил идэвхтэй хайж байсан хүмүүсийн тоо мэдэгдэхүйц багассан байна. Түүнчлэн Дэлхийн банкны төслөөр Өлгий хотын гэр хорооллын цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулан, алдагдлыг бууруулах 2,1 тэрбум төгрөгийн өртөгтэй ажлыг энэ онд дуусгасан байна. Бас Өлгий хотын дулааны зуухын тоног төхөөрөмжийг шинэчлэх ойрын болон дунд хугацааны төслийг бэлэн болгож, Эрдэс баялаг эрчим хүчний яамтай хамтран хэрэгжүүлэхээр идэвхтэй ажиллаж байна. Аймаг байгуулагдсаны 70 жилийн ой угтаж Өлгий хотын авто болон явган хүний замыг засварлах, шинэчлэн сайжруулах 1,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг эхлүүлсэн нь олон хүнийг ажилтай болгох, хотын өнгө төрхийг сайжруулахад үр дүнгээ өгч байна.

Үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2009 онд аймгийн Засаг даргаас төсвийн захирагчид, менежерүүд, аж ахуйн нэгжийн дарга эрхлэгчидтэй байгуулсан гэрээнд бодит үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр буй болгох асуудлыг нэг гол шалгуур үзүүлэлт болгон оруулж, хэрэгжилтийг нь хянаж байна. Эдгээр ажлын үр дүнд 2008, 2009 онд 2969 хүн байнгын, 1215 хүн түр ажлын байраар хангагдсан нь хямрал, хүндрэлтэй энэ үед чамлах үзүүлэлт юм.

Өнгөрсөн хугацаанд байршлын давуу талаа ашиглан гадаад харилцаагаа өргөтгөж хөгжүүлэх, түүнийг үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд чиглүүлэх талаар мөрийн хөтөлбөрт

тусгасан зорилтуудыг үндсэнд нь биелүүлсэн байна. Тухайлбал, өнгөрсөн онд ОХУ, БНХАУ-ын хил залгаа муж, районуудын удирдлагуудтай хилийн уулзалт, ажил хэрэгч зөвлөлгөөнийг хэд хэдэн удаа хийж, хилийн худалдааг хөнгөвчлөх, иргэд, зорчигчдод учирч байгаа чирэгдэл бэрхшээлийг арилгах асуудлыг тодорхой баримттайгаар илэн далангүй ярилцан дээрх асуудлуудаар харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан нь үр дүнтэй болсон байна.

Энэ онд БНХАУ-ын ШУӨЗО-ны 50 гаруй пүүс, компани оролцсон үзэсгэлэн, яармаг худалдааг Өлгий хотод зохион байгуулж, түүнд Увс, Ховд аймаг, ОХУ, Казахстаны хил залгаа муж, районы удирдлага, аж ахуйн нэгжүүдийг урьж оролцуулсан нь хамтын ажиллагааг хөгжүүлэхэд түлхэц өглөө.

Энэ үзэсгэлэн худалдааны үеэр худалдаа, бараа солилцоог өргөтгөх, тус аймагт бага оврын барилгын материалын болон цементийн үйлдвэр, МАА-н арьс шир боловсруулах, байгалийн баялагийг хамтран ашиглах зэрэг чиглэлээр гэрээ хэлэлцээрүүд байгуулагдаж тэдгээрийг бодит ажил болгох ажлыг идэвхтэй хөөцөлдөж байна.

Гадаад харилцааны чиглэлээр зорилго чиглэлтэй үйл ажиллагаа явуулсны үр дүнд хийгдсэн бодитой ажлууд гэвэл; Турк улсын ОУ-ын “Тика” байгууллагын 46,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Өлгий хотын 3,6 км замыг гэрэлтүүлэгтэй болгож, аймгийн төвд баригдах асрамжийн газрын барилгын хөрөнгийн 2/3-ыг Турк улс олгох асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн, НҮБ-ын төслийн шугамаар аймгийн РНС-ыг шинэчлэх талаар эцсийн тохиролцоо хийсэн, Казахстан улсын их, дээд сургуулиудад тус аймгийн багш нарыг мэргэжил дээшлүүлэх, тэндээс нарийн мэргэжлийн багш нар манайд урилгаар ажиллуулдаг систем тогтсон, Казахстан, ОХУ-ын хил залгаа муж, район, тус аймгийн хүүхэд залуучуудын хооронд урлаг соёл, спортын нэгдсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг уламжлалтай болсон зэрэг юм. 2009 оны эцсээр Турк улсын 1,1 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламжаар эмзэг бүлгийн иргэдэд мах, хүнсний зүйл олгогдлоо. Энэ үйл ажиллагаанд Өлгий сумын ЗДТГ-ын Монгол-Туркийн хамтарсан сургууль, “Салем” мешит, Монголын Мусульманы нийгэмлэг илүү их ачаалалтай ажилласан байна.

Энэ бүхэн нь аймгийн иргэдийн амьдрал ахуй, соёл боловсролыг дээшлүүлэхэд үр өгөөжтэй болжээ.

Хоёр. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн талаар дэвшүүлсэн зорилт, хэрэгжилтийн байдал

Тус аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувийг үйлдвэрлэдэг хөдөө аж ахуйн салбарын талаар аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт 10 багц асуудал тусгаж, хэрэгжилт нь 98 хувьтай байна.

Тайлангийн хугацаанд мал сүргийг эрүүлжүүлэх, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, мал эмнэлэг, үржлийн албаны үйлчилгээг зах зээлийн өнөөгийн нөхцөлд нийцүүлэн сайжруулахад гол анхаарлаа төвлөрүүллээ. Энэ онд улсын төсвөөс аймгийн хэмжээний 70 шахам мал эмнэлгийн нэгж салбарт малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд жил бүр 241 сая төгрөг олгож, 500,0 гаруй сая төгрөгийн вакцин, эм, тарилга нийлүүллээ. Үүний үр дүнд давхардсан тоогоор 4,0 сая гаруй малд халдварт болон паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, туулгалт хийсэн байна. Энэ хугацаанд мал эмнэлгийн нэгжүүдийн үйл ажиллагааны стандартын түвшинг тогтоож, хувийн мал эмнэлгийн эмч нарыг

Улаанбаатар хотод нэгдсэн сургалтанд хамруулж, нэгж тус бүрт Нэг сая орчим төгрөгийн эм багаж хэрэгслийг төслийн шугамаар олгосон нь тэдгээрийн чадавхийг дээшлүүлэхэд ач холбогдолтой болжээ.

Тус аймагт 2009 онд сүүлийн жилүүдийн нэгэн адил малын голц халдварт өвчин гараагүй, ийм өвчнөөс тайван статустай аймгийн тоонд бүртгэгдэж улмаас МАА-н түүхий эд бүтээгдэхүүнийг гадаад, дотоод зах зээлд чөлөөтэй борлуулах боломжтой байгаа нь гол амжилт юм.

Мэргэжлийн байгууллагууд мал сүргийн чанар, ашиг шимийг дээшлүүлэхэд чиглэсэн ажлыг бодлого төлөвлөгөөтэй хийж байгаагийн дотор сүүний чиглэлийн үхэр, ямааны өндөр ашиг шимтэй хээлтүүлэгчийн гүн хөлдөөсөн үрээр нутгийн малыг зохиомлоор хээлтүүлэх ажлыг эхлүүлсэн нь цаашид мал сүргийг хамгийн бага зардлаар богино хугацаанд, орчин үеийн биотехнологийн аргаар эрчимжүүлэх эхлэл болсон байна.

Төр засгаас хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих үүднээс хэрэгжүүлж байгаа “Малын тэжээл”, “Ногоон хувьсгал”, “Малын эрүүл мэнд” “Эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх” малын чанар сайжруулах зэрэг хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж байна. Төр, засгийн эдгээр бодлого шийдвэрийг ард иргэд дэмжиж хамтран ажилласнаас зарим үр дүн гарч эхэллээ. Тухайлбал, Өлгий хотын орчим 10-15 үнээтэй үнээний 5 бичил фермерийн аж ахуй, тахианы 2 жижиг ферм гүү, ингэний төрөлжсөн фермерүүд ажиллаж байгаа төв суурин газрын иргэдийг сүү, хоормог, өндөгөөр хангахад бага ч болов хувь нэмэр оруулж байна.

Манай аймгийн мал аж ахуйн салбарын хамгийн тулгамдсан асуудал болох тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд анхаарч, хуучин ашиглаж байсан услалтын системүүдийг сэргээн засварлах, шинээр усалгааны систем барих ажил Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэмжлэгээр хийгдэж байна. Тухайлбал энэ онд Сагсайд 200, Их буланд 130 га, Булган суманд 300 га, Улаанхус, Цэнгэл суманд тус бүр 200 га-гийн усалгааны системийг 600,0 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сэргээн засварлах, шинээр барих арга хэмжээ авлаа. Сүүлийн 1 жилд малчид хадланд ашиглаж болох 2200 га талбайг хашиж, усалж тордон ургацыг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан байна. Үүний үр дүнд энэ онд бэлтгэсэн хадлан өнгөрсөн оныхоос 6,0 мянган тн-оор нэмэгдэж тус аймаг ХХААХҮ-ийн яамнаас зарласан болзолд шалгарч нэг сая төгрөгөөр шагнагдсан байна.

2009 оны өвөл хаврын зуд, цаг агаарын бэрхшээлээс малчид, мал сүргийг хамгаалах талаар онцгойлон анхаарч, тусгайлан арга хэмжээ авсныг та бүхэн мэднэ. Тухайлбал, төв, орон нутгийн Засаг захиргааны байгууллагууд малчдад улсын нөөцөөс 460 тн өвсийг үнэгүй тарааж, 450 орчим тн өвс, 630 гаруй тонн хүчит тэжээлийг 50 хувийн хөнгөлөлтэй үнээр олгосон нь хохирлын хэмжээг бууруулахад нөлөөлсөн гэж үзэж байна. Мөн 2009 онд улсын нөөцөнд бэлтгэсэн өвс тэжээлийн хэмжээ өнгөрсөн оныхоос 2 дахин нэмэгдсэний дээр Сагсай сумын Даянд шинээр шинээр улсын нөөцийн тэжээлийн цэг байгууллаа.

Хэдийгээр төв, орон нутгийн төр засгийн байгууллагуудаас мал сүргийг ган зудаас хамгаалах, малчдыг дэмжих үүднээс багагүй хөрөнгө зарж байгаа боловч малын хорогдол төдийлэн буурахгүй байна. Үүний гол шалтгаан нь байгаль, цаг уур

өөрчлөгдөж ургамлын бүрхэвч хомсдон, цөлжилт нэмэгдэж, малын тоо өсөхийн хирээр бэлчээрийн талхлагдал ихэсч байгаатай холбоотой юм. Иймд манай малчид, мал бүхий иргэдийн өмнө малын тоог хязгаарлаж чанарыг сайжруулах, нэгжээс ашиглах бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх чиглэл рүү шилжихээс өөр замгүй болоод байна.

Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд мал мах, түүхий эдийн үнийн уналт, мах экспортлох зах зээл олдохгүй байгаа явдал энэ салбарын тулгамдсан асуудлын нэг болж байна. Сүүлийн жилүүдэд тус аймаг дахь Цагааннуурын боомтоор Орос, Казахстанд хилийн худалгаагаар гаргаж буй бага хэмжээний махыг эс тооцвол мал мах гараагүй, төвийн бүс, төвлөрсөн зах зээлд мал борлуулаагүйгээс малын тоо өсч, улмаар зуднаар хорогдон, малчдын орлого хомсдож, малаа хорогдуулсан иргэд аймаг, сумын төв бараадан ажилгүйчүүдийн эгнээг нэмэгдүүлж байна. Ганц жишээ дурьдахад: сүүлийн 5 жилд тус аймгаас 306 мянган толгой мал хорогдсоноор малчид 17,0 тэрбум төгрөгийн хохирол амссан байна. Хэрэв зах зээл байгаад малаа борлуулж чадсан бол малчид ийм хохирол амсахгүй байсан..

Мал, мах борлуулах, экспортлох асуудал нь зөвхөн манай аймаг төдийгүй баруун бүсийн хэмжээнд шийдлээ хүлээсэн хурц асуудал хэвээрээ байна. Манай улсын хувьд амьд мал хөлөөр нь гаргах, мах экспортлох асуудлыг чөлөөтэй болгосон ч хөрш зэргэлдээ орнуудын хилийн мал эмнэлгийн болон хяналтын байгууллагууд нь өндөр шалгуур тавьж байна.

Иймд мал, мах экспортлох асуудлыг өндөр түвшинд тавьж тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх нь малчдын талаар төрөөс баримтлах бодлогын хамгийн чухал асуудлын нэг болсон. Ийм ч учраас тус аймгийн Засаг дарга баруун 3 аймгийн Засаг дарга нартай хамтран хөрш орнуудад мах, амьд мал экспортлох асуудал боловсруулж Засгийн газарт тавьж хөөцөлдөж байна.

Газар тариалангийн салбарын хувьд тариаланд тохиромжтой талбайг бүрэн ашиглах, тариаланчдыг бага оврын техник олж авахад нь дэмжлэг үзүүлэх, шаардлагатай үр, үрслэгээр хангах, тэднийг урамшуулах талаар анхаарч ажилласан юм. Энэ онд аймгийн тариаланчдийн зөвлөлгөөнийг Баяннуур суманд хийж хөрс боловсруулах, парник, хүлэмж барих, суулгац бэлтгэх талаархи Баяннуур сумын тариаланчдын ажлын арга туршлагыг бусад сумдын тариаланчдад үзүүлж танилцуулсаны гадна “Монгол төмс” хөтөлбөрийн хүрээнд төмсний өвчин хортонтой

тэмцэх, тарьж ургуулах баруун бүсийн сургалтыг мөн Баяннуур суманд амжилттай зохион байгууллаа.

Уг зөвлөлгөөнд баруун бүсийн аймгуудын 80 гаруй тариаланч оролцсоны гадна Дархан дахь Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн мэргэжилтнүүд оролцож тариаланчдад нарийн мэргэжлийн зөвлөлгөө өгсөн нь үр дүнтэй арга хэмжээ боллоо.

Төмсний үр хуучирч ургац буурч өвчин хортонд нэрвэгдэж байсанд дүгнэлт хийж төмсний үр сэргээн сайжруулах хөтөлбөрийн хүрээнд үр үржүүлэгчдийг сонгон авч 20 тонн вирусгүй сортын үрийг үржүүлэх замаар төмсний үрийг дэс дараатай шинэчилж байгаагийн дээр энэ онд НҮБ-ын хүнс хөдөө аж ахуйн байгууллагын шугамаар өрхийн хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 17 тонн Астила сортын төмсний үрийг 250 өрхөд олгож 90 тонн вирусгүй төмс хурааж авсан байна.

Газар тариалангийн техник хуучирч, үйлдвэрлэл явуулах боломж алдагдаж байсныг харгалзан тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, хувь хүмүүст 50 хувийн хөнгөлөлттэй үнээр бага оврын трактор, дагалдах хэрэгслийн хамт олгосны дээр зөвлөлгөө, арга зүй, техникийн туслалцаа үзүүлэх зориулалт бүхий агропаркийг бүх суманд байгуулсан юм.

Эдгээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний үр дүнд 2009 онд аймгийн хэмжээгээр 3800 өрх тариалан эрхэлж 396 гад төмс, 110 гад хүнсний ногоо тариалж, 3400 шахам тонн төмс 1142 тонн хүнсний ногоо хураасан нь аймгийн хэрэгцээт төмсний 60, хүнсний ногооны 17 хувьтай тэнцэж байгаа юм.

Аймаг, сумын төвийн 320 өрх хашаандаа жижиг хүлэмжтэй болж нарийн ногоо тарьж байгаа нь хүнсний ногооны нэр төрөл, хангамжид бага ч болов хувь нэмэр болж байна.

Газар тариалангийн салбарт зохих ахиц өөрчлөлт байгаа боловч цаг агаарын өөрчлөлт хуурайшилттай холбоотой голын усны түвшин буурснаас усалгааны горим алдагдах, тариалалт оройтох, услалтын системүүдийн талбай гүйцэд ашиглагдахгүй байгаа зэрэг бэрхшээл байна.

Иймээс аймгийн газар тариалангийн салбарыг сэргээх ялангуяа усалгаатай тариаланг хөгжүүлэх талаар тусгай хөтөлбөр боловсруулах шаардлагатай байна.

Гурав. Нийгмийн хөгжлийн салбарт дэвшүүлсэн зорилт биелэлтийн явц, байдлын талаар

Засгийн газрын болон аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрүүдэд хоорондоо нягт уялдаатайгаар дэвшүүлсэн “хүнээ тэтгэх нийгмийн үүргийг өндөржүүлэх, иргэнээ дэмжих төрийн үйлчилгээг хэрэгжүүлэх” цогц бодлогын хүрээнд 2009 онд орон нутагт 27 төрлийн ажил хийхээр төлөвлөснөөс одоогийн байдлаар 26 ажил хийгдэж, биелэлт нь 96,9 хувьтай байна.

а/ Хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилтыг хэрэгжүүлэх талаар

Аймгийн эрүүл мэндийн салбарын хувьд эхний ээлжинд аймаг, сум, өрхийн эмнэлгийн ажлын нөхцөл, тоног төхөөрөмжийн хангамжийг эрс сайжруулах, эмч мэргэжилтнүүдийг чадваржуулах замаар тус аймагт харьцангуй өндөр байгаа эх нялхсын эндэгдлийг тууштай бууруулах, ард иргэдээ халдварт өвчнөөс хамгаалах асуудлыг тэргүүн эгнээнд тавьж зарим тодорхой ажлуудыг хийж эхэллээ. Тухайлбал, аймгийн нэгдсэн эмнэлэгт ОУ-ын болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар алсын түргэн тусламжийн туулах чадвар сайтай гурван автомашин, 200,0 орчим сая төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмжийг нийлүүлсний дээр Толбо сумын эмнэлэгт түргэний машин, Дэлүүн, Цэнгэл, Булган, Алтай, Буянт зэрэг хэд хэдэн суманд НҮБ-ын Хүн амын сан “Дэлхийн зөн” олон улсын байгууллагын болон Тогтвортой амьжиргаа төслийн 155,0 сая төгрөгийн санхүүжилтээр ЭХО аппарат болон чухал шаардлагатай тоног төхөөрөмж олгож, чадавхийг нь дээшлүүлэх арга хэмжээ авлаа. Алтанцөгц сумын хүн эмнэлэг 10,0 сая төгрөгийн төслөөр орчин үеийн физик эмчилгээний аппараттай боллоо.

2009 онд аймгийн нэгдсэн эмнэлгийн дотоод сүлжээг сайжруулах зорилгоор Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 6,0 сая, эхчүүдийн эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагаанд зориулан 4,0 сая төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүллээ.

2009 онд Булган, Баяннуур, Алтай, Ногооннуур суманд шинээр барих эмнэлгийн барилгын зураг төслийг хийж 2010 онд ажлыг нь эхлэх, ашиглалтанд оруулах нөхцлийг бүрдүүлсний дээр

Цэнгэл, Дэлүүн сумын хүн эмнэлгийн салбарын их засварын ажлын төсвийг бэлэн болгож ирэх онд гадаадын төслөөр хэрэгжүүлэхээр тохирлоо. 2009 онд 10 багийн бага эмч нарыг мотоциклтэй болголоо.

Эмч, мэргэжилтнүүдийг чадваржуулах ажлын хүрээнд төвлөрсөн болон бүсчилсэн 6 удаагийн сургалтанд нийт 150 эмч, мэргэжилтнүүдийг хамрууллаа. Түүнчлэн нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг чиглэсэн зорилготой, системтэй болгосон нь үр дүнгээ өгч эхэллээ. Хүн ардын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн үндэсний хэмжээний “халдварт өвчинтэй тэмцэх”, “Халдварт бус өвчнөөс сэргийлэх”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” зэрэг нийт 10 хөтөлбөрийг нутгийн захиргааны байгууллагын хяналтанд

байнга авч дэмжлэг үзүүлж байгаа нь энэ салбарт тавьсан зорилгыг биелүүлэхэд ихээхэн түлхэц болж байна.

Өнгөрсөн онд тус аймагт Дэлхийн банкны санхүүжилтээр “Шувууны томуу, цар тахалтай тэмцэх нь” сэдвээр улсын хэмжээний сургалт, “Эхийн эндэгдлийг бууруулж, нярайн тусламжийг сайжруулах нь” сэдэвт зөвлөлгөөнийг зохион байгуулсан нь эмч, мэргэжилтнүүдийн чадавхи, хариуцлагыг дээшлүүлэхэд үр дүнтэй болсон.

Энэ оны 10-р сараас улс, аймгийн хэмжээнд дэгдсэн гахайн ханиадны цар тахалтай тэмцэхэд аймгийн эрүүл мэндийн байгууллага, Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс хуулинд заасан үүргийнхээ дагуу өндөр зохион байгуулалттай ажиллаж, хохирол багатай даван туулах боломж бүрдүүлсэн байна.

Эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа “Эрүүл мэндэд ээлтэй байгууллага, засаг дарга” шалгаруулах болзол зарлах, сумын эмнэлгийн эрхлэгч, багийн бага эмч, эрүүл мэндийн газрын дарга нарын хооронд “Эх нярайн эрүүл мэндийг хамгаалах” гурвалсан гэрээ байгуулсан зэрэг шинэлэг ажлууд төрийн захиргааны байгууллагын санаачлага, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ боллоо.

Энэ оноос нийт сумдад нарийн мэргэжлийн эмч нарын багийг тодорхой хуваариар ажиллуулж, үзлэг, үйлчилгээ, сургалтыг хослуулж хийж эхэлсэн нь иргэдийн хүсэн хүлээдэг ажлын нэг боллоо.

Эдгээр ажлын үр дүнд 1-5 насны хүүхдийн эндэгдэл, сүрьеэ зэрэг халдварт өвчин буурсан сайн үзүүлэлт гарсан боловч эхийн болон 0-1 насны хүүхдийн эндэгдэл нэмэгдсэн нь сэтгэл зовоосон асуудал хэвээр, цаашид хийх ажил их байгааг харуулж байна.

2010 онд эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах талаар бүх шатны засаг захиргааны болон эрүүд мэндийн байгууллага, иргэдийн өөрсдийн нь оролцоог нэгтгэсэн цогц арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

2009 онд биеийн тамир, спортын талаар авах арга хэмжээг хүн амыг эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх ажилтай нягт уялдуулах, аймгийн Биеийн тамир, спортын газар, Чийрэгжүүлэх төв, клубуудын үйл ажиллагааг дэмжихэд чиглүүлсэн болно. Өнгөрсөн онд оюутны спортын II их наадмыг амжилттай зохион байгуулсны дээр манай аймгийн тамирчид залуучууд улсын болон олон улсын уралдаан тэмцээнүүдэд амжилттай оролцлоо. Тухайлбал, 2009 онд манай аймгийн 50 гаруй тамирчин тив, олон улсын болон улсын чанартай тэмцээнд бокс, үндэсний сур зэрэг 6 төрлөөр оролцож 8 алт, 15 мөнгө, 5 хүрэл медаль хүртсэн байна.

Ирэх онд Өлгий хотод Спорт цогцолбор ашиглалтанд орсноор биеийн тамир, спортын хөгжилд томоохон ахиц гарна гэж үзэж байна.

б/ Боловсрол, соёлын салбарт дэвшүүлсэн зорилтын биелэлтийн талаар

Боловсролын салбарт сургалтын орчин, нөхцлийг цаашид сайжруулах, багш нарын ур чадварыг дээшлүүлэх, хамран сургалтыг нэмэгдүүлж, завсардалтыг бууруулах замаар ялангуяа тус аймагт доогуур байгаа сургалтын чанар, ерөнхий шалгалтын дүнг ахиулах, улмаар хүүхэд залуучуудын боловсролын чанарт дэвшил гаргах зэрэг цогц зорилтууд дэвшүүлж тэдгээрийг үе шаттай хэрэгжүүлэх арга хэмжээ авч ирлээ. Тухайлбал

Өлгий хотод шинээр 2 цэцэрлэг, нэг бага сургууль. Сагсай сумд бага сургууль байгуулан, Ногооннуур, Улаанхус, Алтай сумдад хүүхдийн цэцэрлэгийн 1-4 бүлэг шинээр нээж ажиллуулснаар СӨБ-ын хамран сургалт 68,5 хувь, 6 настай хүүхдийн хамран сургалт 94,4 хувьд хүрлээ. Энэ онд Цэнгэл, Дэлүүн сумдын ахлах сургуулиудын дотуур байранд их засвар, Алтай, Сагсай сумын Ахлах сургуулийн өргөтгөл хийж, Баяннуур, Сагсай, Цэнгэлийн сургуулийн дотуур байрны үйлчилгээг сайжруулах төсөл хэрэгжүүлэн 1500 хүүхдийн суралцах, амьдрах орчинг сайжрууллаа. Ийнхүү 2009 онд нийт дүнгээр боловсролын салбарт 1,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ.

ЕБС-ийн багш нарыг чадваржуулах зорилгоор энэ хичээлийн жилд анх удаа багш нарын дунд сонгон шалгаруулалт явуулж, чансаагаар нь байр эзлүүлж багшлах боловсон хүчнийг шилэн сонгох журам нэвтрүүлсний дээр нийт багш нарын 68 хувь нь мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж мэргэжилтэй багш нарын хангалт 99,3 хувьд хүрсэн байна.

2009 онд боловсрол, соёлын байгууллагын чадавхийг дээшлүүлэх, багш, мэргэжилтнүүдийн ур чадварыг сайжруулах ажлын хүрээнд нийт ЕБС, соёлын төвүүдийн 57 хувийнх нь үйл ажиллагаанд иж бүрэн хяналт, шинжилгээ хийж, арга зүйн зөвлөлгөө өгсөн байна.

Тайлангийн хугацаанд боловсролын салбарт хийсэн нэг томоохон ажил бол “Казах хүүхдийн боловсролыг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан түүний дагуу БСШУ-ны яам, Боловсролын хүрээлэн, аймгийн Боловсрол, соёлын газрын хамтарсан ажлын хэсэг байгуулан орон нутагт ажиллуулж, казах сургуулийн сургалтын стандартын эхний хувилбарыг боловсруулах ажлыг зохион байгуулсан явдал юм. Уг ажлын хэсэг тус аймгийн боловсролын чанарт нөлөөлж байгаа хүчин зүйлийг нарийвчлан судлаж бидний ажилд нэн тустай тайлан, зөвлөмж гаргасан.

Мэргэжлийн боловсролын чанарыг дээшлүүлэх ажлын хүрээнд Өлгий хот дахь Багшийн коллежийн хичээлийн байранд 200,0 орчим сая төгрөгийн их засвар хийж, 300,0 гаруй сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж нийлүүлэн сургалтын орчинг сайжрууллаа. Түүнчлэн тус аймаг дахь МСҮТ-ийн дотуур байранд их засвар хийж, сургалтын төлөвлөгөөг нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэнд нийцүүлэн уян хатан болгож, менежментийг нь шинэчлэн сайжруулах арга хэмжээ авснаар нэр хүнд нь дээшилж, элсэгчдийн тоо өнгөрсөн оныхоос 30 хувиар нэмэгдсэн байна.

Казах сургуулиудын сурах бичгийн хангамж өнгөрсөн оныхоос ахисан дүн мэдээтэй байна. Энэ салбарт энэ мэт хийгдэж байгаа ажил, ахиц дэвшил байгаа боловч сургалтын орчныг сайжруулах, багш нарын ур чадвар, хариуцлага, сургалтын чанарыг дээшлүүлэх талаар хийх

ажил их байна. Энэ талаар Засгийн газраас тусгайлан тогтоол гаргахаар шийдвэрлэсэн бөгөөд одоо төсөл нь бэлэн болоод байна.

2009 онд соёлын байгууллагуудын материаллаг баазыг сайжруулах, соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн ажлуудыг зохион байгууллаа. Тухайлбал, ХД театрын уран бүтээлчдийн багийг тусгай графикайн дагуу нийт сумдаар аялуулан тоглуулж, Алтай, Буянт суманд ХД театрын нэгдсэн тоглолт хийлгэсэн нь иргэдийн талархлыг хүлээсэн арга хэмжээ боллоо.

Сумдын соёлын төвүүдийн үйл ажиллагааг чадваржуулах зорилгоор жил бүр бүх сумдын соёлын төвүүдийн хооронд ур чадварын тэмцээнийг ээлж дараатай нэг суманд зохион явуулж байна. Энэ жил Булган суманд бүх сумдын соёлын төвүүдийн ур чадварын уралдааныг амжилттай зохион байгуулж Буянт сумын соёлын төв 1-р байр, Цэнгэл сумын соёлын төв 2-р байр, Сагсай сумын соёлын төв 3-р байруудыг эзэллээ.

Аймгийн орон нутаг судлах музейг судалгаа шинжилгээ, танин мэдэхүйн танхимтай болгож сургуулийн сурагчдын орон нутаг судлах хичээлийн цагийг уг танхимд явуулах ажлыг зохион байгуулж байна. Мөн сумдын соёлын төвүүдэд орон нутаг судлах кабинет, булантай болгох шаардлага тавьж, Булган сумын соёлын төвийг жишээ болгож бүх сумдын соёлын төвүүдийн эрхлэгчдэд үзүүлэх сургалт зохион явууллаа.

Цаашид ХД театрын уран бүтээлчдийн бүрэлдэхүүнийг театрын стандартын түвшинд хүргэж нэмэгдүүлэх, чадваржуулах, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах шаардлага тулгарч байна.

в/ Нийгмийн хамгааллын чиглэлээр хийж байгаа ажлын талаар

Төрийн нийгмийн хамгааллын бодлогыг орон нутагт зохион байгуулж хэрэгжүүлэхдээ юуны өмнө иргэдийг ажилтай, орлоготой болгох асуудлыг тэргүүн эгнээнд тавьж байна. Энэхүү цогц асуудлыг үе шаттай шийдвэрлэхийн тулд эхний ээлжинд иргэдийг зах зээлийн нөхцөлд бие дааж амьдрах арга ухаанд сургах, тэднийг мэргэжилтэй, боловсролтой болгоход чиглэсэн зарим практик алхамуудыг хийж байна. Тухайлбал, Тогтвортой амьжиргаа төслийн нэгж, Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран иргэдийн дунд төмс, хүнсний ногоо тариалах, өрхийн болон фермерийн аж ахуй эрхлэх, МАА-н бүтээгдэхүүн боловсруулах зэрэг чиглэлээр богино хугацааны эрчимжсэн сургалт, сурталчилгаа хийдэг уламжлалтай боллоо. Энэ ажлын хүрээнд өнгөрсөн онд 3,0 мянган өрхийг төмс, хүнсний ногооны үр бордоогоор хангасан байна.

Түүнчлэн зайлшгүй нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдвал зохих иргэдийн судалгааг сум, баг бүрээр нарийвчлан гаргаж, тэднийг нийтийг хамарсан ажилд зохион байгуулж оролцуулах, хоршоо, нөхөрлөл, бүлэг байгуулах санаачлагыг нь дэмжиж урамшуулах замаар ажил, амьжиргааны эх үүсвэртэй болгох арга хэмжээ авч байна. 2009 онд энэ чиглэлийн үйлчилгээнд 4,0 мянган иргэн хамрагдсан байна.

Төрөөс үзүүлж байгаа халамжийн үйлчилгээ нь эмзэг бүлгийн иргэдийн амьжиргааг дэмжихэд нэн чухал үүрэг гүйцэтгэж байна. 2009 онд 9,3 тэрбум төгрөгийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь нь 2008 оныхоос даруй 1,0 тэрбум төгрөгөөр илүү байна.

Ахмад настан, эхчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмж, холбогдох хуулийн хэрэгжилтийн байдалд бүх шатны Засаг дарга нар бүртгэлээр хяналт тавьж байна.

**Дөрөв. Байгаль хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх
чиглэлээр хийж байгаа ажлын талаар**

Алтайн өндөр уулын болон говь, цөл хосолсон эмзэг экосистем бүхий бүс нутагт оршдог тус аймгийн хувьд байгаль орчныг хамгаалахад ард иргэд, нутгийн захиргааны байгууллагын анхаарлыг чиглүүлж зарим ажлуудыг зохион байгуулж хийлээ. Юуны өмнө 2009 онд байгаль хамгаалах үүрэг бүхий мэргэжлийн байгууллагуудын чадавхийг дээшлүүлэхэд анхаарч аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрыг шинэ байртай, Ус цаг уур, орчны шинжилгээний төвийг үүлэнд зориудаар нөлөөлж бороо оруулах төхөөрөмжтэй болгож, энэ хоёр газрын нийт ажилтнуудыг бүсийн болон төвлөрсөн сургалтанд хамруулж, мэргэжлийг нь дээшлүүллээ. Хамгийн ихээр цөлжиж байгаа төв, суурин газрууд болон бэлчээр нутгийн судалгааг нарийвчлан гаргаж Өлгий, Бугат сумын нутагт “Нисэх буудал-Ногоон бүс”, “Шарнуур-ногоон бүс” гэсэн хоёр томоохон төслийг мэргэжлийн түвшинд боловсруулж, хөрөнгийн эх үүсвэрийг нь хөөцөлдөж байна.

Мөн байгаль хамгаалах зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Байгаль, орчин аялал жуулчлалын яамтай хамтран “Алтай соёны экологийн үнэт зүйлсийг ард иргэдийн оролцоотойгоор хамгаалах” төслийн нэгж, Монгол Алтайн Нурууны болон Хөх сэрхийн нурууны улсын тусгай хамгаалалттай захиргааны ажилтан, мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулж, чадваржуулах арга хэмжээ авлаа. Тус аймагт шинээр мөс судлалын станц байгуулахаар болж орон тоог нь шийдвэрлүүллээ.

Түүнчлэн Өлгий, Цэнгэл, Улаанхус, Баяннуур сумдын нутагт ойжуулалт хийж, мод бут, жимс жимсгэнэ тариалах ажлыг өргөтгөлөө.

Тус аймаг нь Монгол Алтайн нурууны ноён оргилуудтай, олон үндэстэн ястны өвөрмөц соёл, зан заншилтай археологийн олдвор, түүхийн дурсгалт газар олонтой зэрэг давуу талаа түшиглэн гадаад, дотоодын аялал жуулчлалыг өргөтгөх талаар тодорхой бодлого, чиглэлтэй ажиллаж байна.

Нутгийн захиргааны байгууллагаас байгалийн болон угсаатны зүйн чиглэлийн аялал жуулчлалыг дэмжих бодлого барьж байгаагийн үр дүнд Алтай Таван богд, Цамбагарав, Хөх сэргийн нурууны чиглэлд аялагчдын тоо жил бүр өсч байна. Түүнчлэн аймгийн ЗДТГ, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдтэй хамтран жил бүр Бүргэдчдийн баяр тэмдэглэдэг уламжлалтай болсон нь гадаадын жуулчдын сонирхлыг ихээхэн татаж байна. Тухайлбал, зөвхөн 2009 онд л гэхэд Бүргэдчдийн баярт хамгийн олон буюу 20 орчим орны 200 гаруй жуулчин оролцлоо.

**Тав. Төрийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй
болгох талаар тавьсан зорилтын биелэлтийн талаар**

2009 онд бүх шатны төрийн захиргааны байгууллагын чадавхи, төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, төрийн албаны ил тод байдлыг хангахад чиглэсэн томоохон зорилтууд дэвшүүлж хэрэгжүүлэх арга хэмжээ авлаа. Юуны өмнө нийт сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарыг төвлөрсөн болон бүсчилсэн сургалтанд бүрэн хамруулж

чадавхийг нь дээшлүүлэх арга хэмжээ авлаа. Энэ онд төрийн захиргааны болон төсөвт албан байгууллагуудын ажлыг үндсэн чиг үүргээ биелүүлж байгаа байдал, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч хариу өгч байгаа байдал, тэдгээрээс санаачилж хийсэн бүтээлч ажил зэрэг тодорхой үзүүлэлтүүдээр дүгнэж нийтэд сурталчилдаг журам тогтоолоо. Түүнчлэн төрийн албаны зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хүнд суртал чирэгдлийг арилгахад онцлон анхаарч төрийн захиргааны байгууллагуудын дотоод журам, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг шинэчлэх ажлыг хийж дуусгаад байна.

Төрийн нэрийн өмнөөс иргэдэд үйлчилдэг эрүүл мэнд, боловсрол, мэргэжлийн хяналт, хөдөлмөр, халамжийн үйлчилгээ, татварын хэлтэс зэрэг байгууллагуудын нээлттэй хаалганы өдрийг аймаг, сумын төвд зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, үйл ажиллагааныхаа утга учрыг иргэдэд танилцуулж, тэдний санал хүсэлтийг сонсч ажилдаа тусгадаг уламжлалтай боллоо.

Дээр дурдсан байгууллагуудын дотроос иргэдийн байнгын анхаарлын төвд байдаг эрүүл мэндийн болон боловсролын байгууллагын ажлын тайланг ард иргэдээр хэлэлцүүлж, үнэлэлт дүгнэлт хийдэг болсон нь ашиг тусаа өгч байна.

2009 онд аймгийн ЗДТГ-т хяналт шинжилгээ, үнэлгээний албыг шинээр байгуулан ажиллуулж эхэлсэн нь бүх шатны төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд болон төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, үр дүнгээ өгч байна.

Өнгөрсөн онд аймгийн хэмжээний нийт төрийн албан хаагчдын бүртгэл, судалгааг тусгай программаар улсын нэгдсэн сүлжээнд оруулсны дээр төрийн албан хаагчдын мэргэжлийн шалгалт, удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг хуулийн хүрээнд явуулж, нөөц бүрдүүлэх, томилгоо хийх ажлыг журам зааврын дагуу хийсэн байна.

Тайлангийн хугацаанд төрийн хууль тогтоомж сурталчлах бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, энэ үндсэн дээр гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд байнга анхаарч ажиллалаа.

Энэ ажлын хүрээнд сум, аймгийн ЗДТГ-уудын хууль тогтоомжийн лавлах сангийн фондыг баяжуулах, шинээр гарсан болон нэмэлт өөрчлөлт орсон эрх зүйн актыг шуурхай бүртгэж байгууллага, албан тушаалтан, иргэдэд хууль зүйн үнэн зөв актаар лавлагаа өгөх ажлыг сайтар зохион байгуулж байна. 2009 оны 11 сарын байдлаар аймгийн ЗДТГ-ын хууль тогтоомжийн лавлах санд нийт 377 эрх зүйн акт бүртгэснээс хууль 161, УИХ-ын тогтоол 61, Засгийн газрын тогтоол 129, Улсын дээд шүүхийн тогтоол, ҮХЦ-ийн дүгнэлт, Ерөнхийлөгчийн хэм хэмжээ тогтоосон зарлиг зэрэг акт 26 байна.

Нийт 120 хуулийн 520 зүйл заалтад нэмэлт өөрчлөлтийн хөдөлгөөн хийгдэж 27 хуулийн 98 зүйл заалт болон Засгийн газрын 64 тогтоолыг хүчингүй болсныг бүртгэжээ.

Эрх зүйн сургалт сурталчилгааны ажлын хүрээнд аймгийн ЗДТГ-ын хууль зүйн хэлтсийн дэргэдэх Эрх зүйн туслалцааны төв чухал үүрэг гүйцэтгэж байна. Энэ төвөөр үйлчлүүлж өөрсдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн олон асуудлаар иргэд маш олноор хандаж хүрээ нь улам өргөжиж байна. Тухайлбал энэ оны эхний 11 сарын байдлаар тус төвөөр 900 гаруй иргэн ирж хууль зүйн зөвлөгөө, лавлагаа авч үйлчлүүлсэн байна. Энэ нь иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдний эрх зүйн албан бус боловсролыг дээшлүүлэхэд үлэмж хувь нэмэр оруулж байгаагийн илрэл мөн.

Эрх зүйн албан бус боловсрол олгох ажлын хүрээнд албан байгууллагуудын ажилтан, албан хаагчдад тодорхой сэдвээр хууль зүйн хичээл заах байдлаар иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх ажил явуулж байгаа бөгөөд аймгийн радиогийн “Иргэн ба хууль” булангаар хууль тогтоомжийг тогтмол сурталчилж байна. Иргэдийн эрх зүйн боловсрол мэдлэгийг дээшлүүлэх ажилд 2009 оны байдлаар аймаг, сумын хэмжээнд 3,3 сая төгрөг зарцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг аймгийн төр, захиргааны болон шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын хүчийг хандуулан жил улирлын төлөвлөгөөтэй зохион байгуулсны үр дүнд 2009 оны эхний 11 сарын байдлаар гэмт хэрэг 16 хувиар буурсан үзүүлэлттэй гарч байна. Гэмт хэргийн гаралт Алтанцөгц, Баяннуур, Булган, Дэлүүн, Толбо, Улаанхус зэрэг сумдад нэлээд дорвитой буурсан байхад Алтай, Буянт, Сагсай, Цэнгэл сумдад 2-3 дахин өссөн нь эдгээр сумдын төр, захиргааны байгууллага, энэ чиглэлээр ирэх онд ихээхэн хүчин чармайлт гаргаж ажиллах шаардлагатайг харуулж байна. Өмнөх жилүүдтэй харьцуулахад малын хулгай, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүд огцом буурч байгаа нь бидний ажлын сайн үр дүнгийн илрэл юм. Үүнд Алтай, Булган, Дэлүүн, Толбо, Цэнгэл суманд малын хулгайн хэрэг огт гараагүй нь аймагт төдийгүй улсын хэмжээнд үлгэр дууриал болохуйц байна.

Хэдийгээр ийм ахиц байгаа боловч хүний амь нас бүрэлгэх, хүчирхийлэх, иргэдийн эрх чөлөөнд халдах, танхайрах, дээрэм хийх зэрэг зарим жигшүүрт гэмт хэргийн гаралт их биш ч гэсэн зохих хэмжээгээр гарсаар байгаа нь анхаарал татсан асуудал болж байна. 2010 онд эдгээр төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага тавигдаж байна.

Гэмт хэргийн гаралтын гол шалтгаан нөхцлийн нэг болсон архидан согтуурах явдал жил ирэх бүр буурах биш нэмэгдэх хандлага цагдаагийн статистик мэдээнээс харагдах боллоо. Энэ байдалд аймаг, сумдын төр, захиргааны болон хууль хяналтын байгууллага, албан тушаалтан, иргэн бүрийн анхаарлыг хандуулж ирэх онд Архидан согтуурахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд онцгой ахиц гаргаж ажиллах хэрэгтэй болж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүрэг бүхий цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүнийг чадавхижуулах аймгийн хэмжээнд гарч буй гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгах, таслан зогсоход хүрэлцэхүйц ажиллах хүч, техник хэрэгслээр хангах зорилтыг 2010 онд дахин дэвшүүлэн хэрэгжүүлэх болно.

Санхүү, төрийн сангийн бодлогын хэрэгжилтийн талаар

Тайлангийн хугацаанд орон нутгийн төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлэх, төсвийн зарцуулалтанд тавих хяналтыг эрс сайжруулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлж ажиллалаа. 2009 онд үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөж, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажлын үр дүнд татвар төлөгчдийн бааз суурь нэмэгдэж орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлэх боломж бүрдлээ.

Энэ оны төвлөрсөн төсвийн орлогын төлөвлөгөөг 299,0 сая төгрөгөөр буюу 45,0 хувиар, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 658,0 сая төгрөгөөр буюу 32,3 хувиар давуулан биелүүллээ.

Санхүү, эдийн засгийн хямрал хүндрэлтэй холбогдон төсөвт байгууллагуудад үүссэн өр, зээлийн асуудлыг нарийвчлан судлаж Сангийн яаманд танилцуулж хөөцөлдсөний үр дүнд өр барагдуулах журмаар төсвийг нэмэгдүүлж, энэ онд өргүй гарах боломж бүрдсэн байна.

2009 онд Булган, Ногооннуураас бусад сумдыг төрийн сангийн сүлжээнд холбож, сумдын төрийн сангийн төлөөлөгчдийг бие даасан орон тоогоор ажиллуулж эхэлснээр төсвийн зарцуулалтанд өдөр тутам хяналт тавих бололцоо бүрдсэн болно.

2010 оны төсвийн орлогын төлөвлөгөөг 2304,9 сая төгрөгөөр төлөвлөн оруулж байгаа нь 2009 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн дундаж түвшингээс 9,8 хувиар их байгаа бөгөөд энэ нь ирэх онд бүхий л нөөц бололцоогоо шавхан ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар 2009 оны үйл ажиллагаанд ийнхүү дүгнэлт хийсний үндсэн дээр 2010 онд дараахь асуудлуудад гол анхаарал төвлөрүүлэн ажиллахаар төлөвлөж байна. Үүнд:

1. Иргэнээ ажилтай, орлоготой, эрүүл, боловсролтой болгох явдлыг урьдын адил бүх шатны хурал, засаг захиргааны байгууллагын эрхэм зорилго болгон дэвшүүлж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

2. Дээрх эрхэм зорилтыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд сум, байгууллага бүр байгалийн баялагийг ашиглах, мах, ноос, ноолуур сүү, цагаан идээ боловсруулах, малын тэжээл бэлтгэх, ахуйн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр үйлдвэр, үйлчилгээ бий болгоход онцлон анхаарах.

3. Асгатын мөнгөний ордыг ашиглаж эхлэх асуудлаар аймгийн ИТХ, Засаг дарга онцгой хүчин чармайлт гаргах.

4. Өлгий-Цагааннуур, Өлгий-Хашаатын чиглэлийн хатуу хучилттай зам барих ажилд идэвхтэй дэмжлэг үзүүлэх.

5. Өлгий хотын Нисэх онгоцны буудлын хатуу хучилттай зурвас, спорт цогцолборын барилгын ажлыг хугацаанд нь дуусгаж, дагалдах тоног төхөөрөмжөөр бүрэн хангах.

6. Аймаг байгуулагдсаны 70 жилийн ой угтаж хийхээр төлөвлөсөн 70 бүтээлч ажлыг хугацаанд нь зохион байгуулж хийлгэхэд бүх нийтийн анхаарлыг төвлөрүүлэх. Үүнд ялангуяа Өлгий хотын зам, талбайг шинэчлэх, ногоон байгууламжуудыг буй болгох замаар өнгө төрхийг нь өөрчлөн сайжруулахад хөрөнгө хүчийг төвлөрүүлэх.

7. Сум, байгууллага бүр 70 жилийн ой угтаж, иргэд олон нийтийн идэвх санаачлагыг өрнүүлэх замаар тодорхой бүтээлч ажлуудыг зохион байгуулж хийх.

8. Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд чанарын ахиц дэвшил гаргах, Алтай, Баяннуур, Булган, Ногооннуур сумдын хүн эмнэлгийн барилгыг барих, Нэгдсэн эмнэлгийг эмчилгээ, оношлогооны орчин үеийн техникээр хангах, сургуулиудын материаллаг баазыг бэхжүүлэх талаар дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлэх.

9. Засгийн газартай хамтран хөрш орнуудад мах, амьд мал экспортлох асуудлыг шийдвэрлүүлэх замаар малчдын орлогыг нэмэгдүүлэх, мал, мах түүхий эд үнэгүйдэхээс хамгаалах.

10. Төрийн захиргааны байгууллагууд, түүний ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх замаар төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай соёлтой болгож, хүнд суртал чирэгдлийг арилгах зэрэг болно.

**Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн
хэрэгжилтийн удааширсан болон тасарч байгаа ШАЛТГААН**

(2009 жилийн эцсийн байдлаар)


| № | Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт | Хэрэгжилтийн явц /Удааширч буй шалтгаан/ |
|---|---|--|
| Эрүүл мэндийн салбар | | |
| 1 | Багийн бага эмч нарыг унаатай болгох арга хэмжээ авна. | 2009 онд аймгийн хэмжээнд 3 багийн бага эмч нарыг унаатай болгосон, удааширалтай байна. |
| 2 | Аймгийн нэгдсэн эмнэлгийг Улаанбаатар хотын клиникийн эмнэлгүүдийн сүлжээнд холбох арга хэмжээ авна. | Аймгийн Нэгдсэн эмнэлгийг ЭНЭШТ, Улсын Клиникийн III эмнэлэгтэй алсын зайн оношлогооны сүлжээнд холбох үйл ажиллагааг Засгийн газар, Эрүүл Мэндийн Яам, бусад холбогдох байгууллагуудад удаа дараа уламжилан хөөцөлдөж байгаа боловч тодорхой шийдвэр гарахгүй удааширч байна. |
| 3 | Эхийн эндэгдэл, нялхсын нас баралт, өвчлөлтийг багасгана. | 2008 онд эхийн эндэгдэл нь 2 (100000-д 83,0 промил) байсан бол 2009 онд 6 (100000-д 254,0 промил) болж нэмэгдсэн. Мөн 0-1 насны хүүхдийн эндэгдэл 2008 онд 41 байсан бол 2009 онд 48 болж нэмэгдсэн байгаа. |
| Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбар | | |
| 4 | ХДТ-ын үзэгчдийн сандлыг шинэчилнэ. | ХДТ-ын ширээ сандлыг шинэчлэх асуудлыг аймгийн удирдлагууд гол асуудал болгон анхаарч ажиллаж байгаа ба хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүйгээс удааширч байна. |
| 5 | Аймаг, сумдын номын сангийн фондыг шинэ номоор баяжуулах, Казахстан улсаас ном нийлүүлэх, казах сонин сэтгүүл захиалах арга хэмжээ авч Номын санг | Аймгийн номын санг интернэтэд холбоход хүчин чадал сайтай 5 ширхэг иж бүрэн компьютер нийлүүлэх 6 сая төгрөг, сүлжээний төлбөрийн асуудлуудын хөрөнгийн эх үүсвэр шаардлагатай байна. |

| | | |
|----|--|--|
| | интернетэд холбоно. | |
| 6 | Цагааннуур тосгоны соёлын төвийн хуучин барилгыг сэргээн, их засвар хийж, соёлын үйлчилгээ явуулах орчинг бүрдүүлнэ, Буянт суманд шинээр соёлын төв барина. | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт сумдын соёлын төвүүдийг шинээр барих, их засвар хийх ажлыг дэс дараатай хэрэгжүүлэх талаар тусгасан боловч Буянт сумд шинээр соёлын төв барих зураг төслийн ажил бүрэн хийгдсэн ба хөрөнгийн асуудлыг 2010 багтаан шийдвэрлэхээр хөөцөлдөж байна. |
| 7 | Өлгий 110/35/10 кв-ын өндөр хүчдэлийн дэд станцаас дизелийн станцын хооронд 6 кВ-ын ЦДАШ барьж, нөөцийн кабель татна. | Зураг төсөл гаргаж материалыг нь бэлтгэсэн, хөрөнгийн эх үүсвэргүйгээс удааширч байна. |
| 8 | Дэд станц ТПЗ ба 4-ийн хооронд нөөцийн кабель тавина. | Агаарын шугам татахаар зураг төслийг нь өөрчилснөөр хойшолсон. Хөрөнгийн асуудал шийдэгдээгүй. |
| 9 | Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх зорилгоор аймагт 1 тэрбум, сум бүрт 50.0 саяас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй “Үйлдвэрлэл хөгжүүлэх сан” байгуулна. | Жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх зорилгоор 83 аж ахуйн нэгж, иргэнд 741,5 сая төгрөгийн зээл олгосон боловч, 381 иргэнд сум бүрт өгөх 50,0 сая төгрөг орж ирээгүйгээс маш олон төслүүд хүлээгдэж байна. |
| 10 | Сагсай суманд цементийн үйлдвэр барина. | Сагсай суманд цементийн үйлдвэр барих талаар БНХАУ-тай гэрээ хийгдсэн, хөрөнгө шийдвэрлэх шатанд байна. |
| 11 | Орон нутгийн тээврийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон бодлого боловсруулж хэрэгжүүлнэ. | Мэргэжлийн байгууллагын саналыг авч, орон нутгийн тээврийн хөгжлийн бодлого боловруулах шатанд байна. |
| 12 | Өскемен-Өлгий-Өскемен чиглэлд том оврын автобусны шинэ маршрут нээж, Казахстан улсаас зорчигч тээвэрлэж буй улс хоорондын автобусыг Өлгийн төвд авто вокзалаас явуулдаг болгоно. | Өлгий - Цагааннуур чиглэлийн үлдсэн 40 км замыг барьж байгаа, зам ашиглалтад орсны дараа уг асуудал шийдэгдэх тул хэрэгжилт удаашралтай байна. |
| 13 | Тээвэр үйлчилгээний төвийн Өлгий салбарын оношилгооны байр, автовокзалын барилгыг барьж ашиглалтанд оруулан ачаа, зорчигч тээврийн стандартын шаардлага хангасан үйл ажиллагаа явуулж нийт сумуудад зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ явуулна. | Оношлогоо, автовокзалын барилгыг барих газрыг олгох шийдвэр гаргасан, зураг төсвийн ажил хийгдэж байна. |
| 14 | Цагааннуурын худалдааны чөлөөт төвийн цэвэр бохир усны барилга байгууламж, нэгдсэн халаалтын зуух, захирагчийн ажлын албаны нэгдсэн конторыг тус тус барьж ашиглалтад оруулна. | Хөрөнгийн эх үүсвэргүйгээс удааширч байна. |
| 15 | Цагааннуурын төвд төрөл бүрийн барааны агуулахын аж ахуй болон үйлчилгээний төв, жижиг үйлдвэр, цех барьж ашиглалтад оруулна | Хөрөнгийн эх үүсвэргүйгээс хойшлогдсон. |
| 16 | Асгатын мөнгө холимог металлын стратегийн ордыг холбогдох дээд байгууллагуудтай хамтран ашиглаж эхлэх... зохион байгуулалтын арга хэмжээ авах. | Асгатын мөнгөн ордод хөрөнгө оруулах, хамтран ажиллах түншийг идэвхтэй хайж байна. Хөрөнгийн боломжгүйгээс хойшлогдсон. |
| 17 | Улаан уул - Цагааннуурын чиглэлийн хатуу хучилттай замыг бариулах | Улаан уул - Цагааннуурын чиглэлийн зам Монгол, Хятад, ОХУ-ын хэмжээнд яригдаж байна. Зураг төсөв |

| | | |
|--|---|--|
| | техникийн нөхцөл бүрдүүлнэ | гаргаж, Засгийн газарт хөрөнгийн 250,0 сая төгрөгний асуудлыг оруулаад байна. |
| Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын бодлого | | |
| 18 | Мах, махан бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг дээшлүүлж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. | Мал, мах экспортох талаар ХХААХҮЯам, Монгол Улсын Засгийн газар, УИХ-ын гишүүдэд албан ёсоор асуудал тавьсан байгаа. Энэ асуудал нь ОХУ, БНХАУ-Монгол Улсын Засгийн газрын шийдэх асуудал юм. |
| Төрийн байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн бодлого | | |
| 19 | Архивын баримтын ашиглалт, хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, лавлагаа, мэдээллийн ажлыг зохих стандарт жишигт хүргэхийн тулд зориулалтын байртай техник хэрэгсэлтэй болгож орчин үеийн технологи нэвтрүүлнэ. | Архивын ерөнхий газараас "ORG-AMS" архив, албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг аймгийн ИТХ-ын чуулганд оруулан, 2010 онд авахаар ажил зохион байгуулж байна. Улсын архив зориулалтын бус байранд байрлаж байгаа, зориулалтын байр барих хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй удааширч байна. |
| 20 | Сагсай сумын Даян ба Улаанбайшинтад баг байгуулна. | Сагсай суманд нэг байг нэмж байгуулсан. Улаанбайшинтад баг байгуулах талаар судлаж байгаа. |
| 21 | Монгол улс, ОХУ болон Монгол улс, БНХАУ-ын тус аймгийн хилийн хэсэгт хилийн инженерийн байгууламжийг хэсэгчлэн сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. | Монгол-Оросын хилийн Асгатын хэсгээр 13 км урт төмөр торон саад баригдсан, Улаанхус хэсгээр торон саад барих асуудлыг Улсад удаа дараа тавьж байгаа, хөрөнгийн эх үүсвэргүйгээс шийдэгдэхгүй байна. |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ

Баян-Өлгий аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2009 оны хэрэгжилтийн явц



■ Баян-Өлгий аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2009 оны хэрэгжилтийн явц